Хамба номун ханы “Увдист рашааны дусал” судрын Шүлгэлсэн орчуулгын онол, практикийн ач холбогдол

Д.Очирбат[1], Д.Шагдарсүрэн[3], Б.Цэрэндагва[2], Ш.Болд[3]

[1]АШУҮИС, МАУОУС, Монгол анагаах ухаан судлалын тэнхим
[2]АШУҮИС
[3]Эм Зүйн Шинжлэх Ухааны Их Сургууль
Цахим шуудан: dochirbat@gmail.com, Утас: 99110990

Түлхүүр үг:
Хамба Номун хан
Судар, онол
Ламын гэгээн
Эм

Товч утга:

Үндэслэл: XVII зууны эхэн үеэс эхлэн Ламын гэгээн Лувсанданзанжанцангийн туурвисан эмчилгээ болон эм, найрлагын талаарх 5 зохиол, Сүмбэ хамба Ишбалжирын “Дөрвөн рашаан”, “Цагаан болор толь” эмчилгээ, эмийн судрууд, тойн Жамбалдоржийн “Үзэсгэлэнт нүдэн чимэг” эмийн ном, Жамбалчойжиданзанпэрэнлэйн “Увдисын далай” эм найрлагын томоохон бүтээлүүд анагаах ухааны практикт өргөнөөр хэрэглэгдэж эхэлсэн[1-3]. **Зорилго:** Ламын гэгээн Лувсанданзанжанцангийн “Увдист рашааны дусал” судрын шүлэглэсэн орчуулга дахь онол практикийн ач холбогдлыг ханиадыг эмчлэх эмийн жишээгээр тайлбарлах. **Арга, аргачлал:** Анализ нь задлах, ялгаж салгах гэсэн утгатай бөгөөд судлаач сонгож авсан объект буюу үзэгдэл юмыг өөрийн сэтгэхүйгээр тодорхой бүрэлдэхүүн хэсгүүдэд ангилна. Ингэснээр тухайн объектын хийсвэрлэж болох үндсэн шинж чанарууд тодорхой бүрэлдэхүүн хэсгүүд дээр илүү тод илэрч гарна. Анализ хийх нь объектыг задлан шинжилснийг шууд дагалдан зайлшгүй хийгддэг сэтгэхүйн логик үйлдэл юм. Энэхүү аргаар Ламын гэгээн Лувсанданзанжанцангийн “Увдист рашааны дусал” сударт байгаа ханиадыг эмчлэх эмийн хэрэглээний утгыг нээн гаргах задлан шинжилж судлав. Задлан шинжилж гарсан үр дүнг нэгтгэн дүгнэх замаар анализ-синтезийн аргыг ашиглав. **Үр дүн:** Бидний судалгаандаа үндсэн материал болгон авсан Лувсанданзанжанцангийн “Увдист рашааны дусал” судар нь Энэтхэг, Төвөдийн анагаах ухааны сонгодог бүтээл болох “Анагаах ухааны дөрвөн үндэс”-ийн “Увдисын үндэс”-т[5] эхлэн суралцахад улам ойр дөхөм болгосноороо тухайн үеийн анагаах ухааны сургуулийн шавь нарт гол гарын авлага нь болж байжээ. **Дүгнэлт:** Хамба Номун хан Лувсанданзанжанцангийн зохиосон 18-н хуудастай “Увдист рашааны дусал” номд хий, шар, бадган, бор, эс шингэсэн, бэтэг, хаван, халуун унгирал, эрхтэн, цул, сав, хэсэг бусаг зэрэг 22 өвчний эмчилгээний аргыг өөрийн туршлагаас гадна Энэтхэг, Төвөдийн анагаах ухааны мэргэдийн олон арван ном судар, гарын авлагыг нарийвчлан судалж бичсэн хамгийн итгэмжтэй эмчилгээний аргуудыг багтаасан бүтээл болох нь тодорхой байна.

Үндэслэл: XVII зууны эхэн үеэс эхлэн Ламын гэгээн Лувсанданзанжанцангийн туурвисан эмчилгээ болон эм, найрлагын талаарх 5 зохиол, Сүмбэ хамба Ишбалжирын “Дөрвөн рашаан”, “Цагаан болор толь” эмчилгээ, эмийн судрууд, тойн Жамбалдоржийн “Үзэсгэлэнт нүдэн чимэг” эмийн ном, Жамбалчойжиданзанпэрэнлэйн “Увдисын далай” эм найрлагын томоохон бүтээлүүд анагаах ухааны практикт өргөнөөр хэрэглэгдэж эхэлсэн[1-3]. Түүнчлэн эдгээр бүтээлүүдээс улбаалан Монголын анагаах ухааны онол, эмчилгээний арга, туршлагаа хуваалцсан олон арван судар номууд гар бичмэл болон барласан хэлбэрээр нийтэд түгсэн байна. Тиймээс эдгээр бүтээлийн онол болон практик ач холбогдлыг судлан

тогтоож 21 дүгээр зууны уламжлалт анагаах ухааны сургалт, судалгаанд ашиглах, шинэ бүтээгдэхүүн, эмчилгээний шинэлэг арга, аргачлалыг үүдэн бүтээх нь нэн тулгамдасан асуудал байгаа билээ.

Бид энэ удаад Ламын гэгээн Лувсанданзанжанцангийн товч намтар, ялангуяа түүний бичсэн эмчилгээний гол гарын авлага “Увдист рашааны дусал” судрын шүлэглэсэн орчуулга дахь эмчилгээний зарим баримтуудыг судлахаар уг сэдвийг сонгон авлаа.

Зорилго: Ламын гэгээн Лувсанданзанжанцангийн “Увдист рашааны дусал” судрын шүлэглэсэн орчуулга дахь онол практикийн ач холбогдлыг ханиадыг эмчлэх эмийн жишээгээр тайлбарлах.

Арга, аргачлал:

Судалгааны ажлын материал:

- Ламын гэгээн Лувсанданзанжанцан མཁན་ཆེན་ཆོས་ཀྱི་རྒྱལ་པོའི་གསུང་འབུམ་ལས་མན་ངག་བདུད་རྩི་ཟེགས་མ་བཞུགས་སོ། Модон барын төвөд судар[4]. (Хувийн цуглуулга)

Анализ-синтезийн арга: Анализ нь задлах, ялгаж салгах гэсэн утгатай бөгөөд судлаач сонгож авсан объект буюу үзэгдэл юмыг өөрийн сэтгэхүйгээр тодорхой бүрэлдэхүүн хэсгүүдэд ангилна. Ингэснээр тухайн объектын хийсвэрлэж болох үндсэн шинж чанарууд тодорхой бүрэлдэхүүн хэсгүүд дээр илүү тод илэрч гарна. Анализ хийх нь объектыг задлан шинжилснийг шууд дагалдан зайлшгүй хийгддэг сэтгэхүйн логик үйлдэл юм. Энэхүү аргаар Ламын гэгээн Лувсанданзанжанцангийн “Увдист рашааны дусал” сударт байгаа ханиадыг эмчлэх эмийн хэрэглээний утгыг нээн гаргах задлан шинжилж судлав. Задлан шинжилж гарсан үр дүнг нэгтгэн дүгнэх замаар анализ-синтезийн аргыг ашиглав.

Үр дүн: Лувсанданзанжанцан машид гарсан XI жарны “согтох төгөлдөр” хэмээх шороон эм туулай жилийн (1639 он) хаврын тэргүүн сарын 15-нд Сайн ноён хан аймгийн Өлзийт овоо (одоогийн Өвөрхангай аймгийн Хангай ханы орчим) гэдэг газар мэндэлжээ. Түүний эцэг Лояг эрх Чөхүр нь Чакраварди хаан хэмээн алдаршсан Их богд эзэн Чингис хааны 27 дугаар үе, Батмөнх даян хааны 10 дахь хөвгүүн Жалайр хунтайжийн 3 дугаар хүү Нонохуй Үйзэн, түүний 4 дүгээр хүү Түмэнхэн сайн ханы Хөндлөн чөхүр (чойхүр) ноён - ཁྲན་དྲ་ཤང་ཚོས་ཁྲན་-ы 13 хөвгүүний дөрөв дэх хүү болж заясан. Лувсанданзанжанцангийн төвөд хэлээр зохиосон олон зүйлийн ухааны зохиол бүтээл 4 боть, 79 иж, 220 анги буй. Эдгээр зохиолоос анагаах ухааны талаар туурвисан 5 зохиол буй.

Бидний судалгаандаа үндсэн материал болгон авсан Лувсанданзанжанцангийн “Увдист рашааны дусал” судар нь Энэтхэг, Төвөдийн анагаах ухааны сонгодог бүтээл болох “Анагаах ухааны дөрвөн үндэс”-ийн “Увдисын үндэс”-т[5] эхлэн суралцахад улам ойр дөхөм болгосноороо тухайн үеийн анагаах ухааны сургуулийн шавь нарт гол гарын авлага нь болж байжээ. Энэтхэгт үүсэж Төвөдөөр дамжин Монголд уламжлагдан хөгжсөн vata, pitta, and kapha (хий, шар, бадган) онол суурилсан анагаах ухааны сургууль нь XVIII-XX зуун эхэн гэхэд улиран дэвших зүй тогтлынхоо жам ёсоор хөгжлийн шинэ шатанд орж “Монгол уламжлалт анагаах ухаан” гэсэн эрдэм ухаан, соёлын үнэт өвийг бий болгожээ. Pancha mahabhutas, vata, pitta, and kapha гэсэн үндсэн онол бүхий Энэтхэгийн Аюурведийн анагаах ухаан нь өмнөөсөө умар зүг рүү, цаст Гималайн өврөөс ар бэл рүүгээ, нэг ёсондоо халуун бүсээс сэрүүн бүс рүү бүр говь, хангай, тэгш тал, эрс тэс уур амьсгалтай Монгол нутагт зохицон хөгжлийн ороон шаталсан дээд түвшинд хүрчээ. Үүний зэрэгцээ уг анагаах ухааны эмийн түүхий эдүүдийг Төв Азийн өргөн уудам газар нутгийн ургамал, амьтан, эрдсийн гаралтай эмийн түүхий эдээр орлуулан, эх нутагтаа зохицсон идээ, ундаа, явдал мөрийн онцлогтоо зохицуулан судар номдоо Монгол мэргэд тэмдэглэн үлдээжээ[6].

Хамба номун ханы буман зарлигаас “Увдист рашааны дусал хэмээх оршвой” төвөд хэлээр མཁན་ཆེན་ཆོས་ཀྱི་རྒྱལ་པོའི་གསུང་འབུམ་ལས་མན་ངག་བདུད་རྩི་ཟེགས་མ་བཞུགས་སོ། Арван найман хуудастай ном[7]. Хий, шар, бадган, бор, эс шингэсэн, бэтэг, хаван, халуун унгирал, эрхтэн, цул, сав, хэсэг бусаг зэрэг 22 өвчинд үзүүлэх эмнэлгийн тусламж, эмэгтэйчүүдэд зонхилон тохиолддог зарим өвчнүүд, халууныг ялган эмчлэх өөрийн туршлага, сургамжаа дүгнэн бичжээ. Жишээлбэл:

Шарын хэмжээ ихдээд ирвэл дэгд-8
Шавдаж хүч нь ихэдвээс барагшин-25-ыг шүт
Шарын дэвэрсэн халууныг бас
Хатуу, зөөлөн туулга хийгээд
Хануур зэрэг заслаар илаарьшуул юу хэмээжээ.

Үндэс хийгээд багшийн аман сургаалаас өдий төдий сурснаа даган орох шавийн тусад зохиов. Үүний буянаар гурван хорын өвчнөөс тонилох болтугай. Энэ нь өөрийн эмийн шинэ шавь нарт туслахыг бодож очир баригч Банчэн, хамгийг айлтгагчийн бодит шавь, доорд ялангуяа утгыг үйлдэх Ютогийн дүр, хувилгаан Лигдэнчинаддагва, Лувсанжамцбалсангийн өршөөлөөр анагаах ухааныг зүгийн төдий үзсэн Жингар тэнгэрийн тойн Лувсанданзанжамцан бээр зохиожээ. Эх бологч амьтан бүхнийг шалтгаан, үрийн өвчнөөс гэтэлгэн, тийн удирдах Эмч, отчийн хутгийг түргэнээ олох болтугай. Ерөнхийдөө бол ”Увдисын үндэс”-ийн товч тайлбар зохиол болно[8].

Энэхүү судалгааны явцад бид “Увдист рашааны дусал хэмээх оршвой” номд байгаа ханиад, хижиг дагшуурыг анагаадаг эмчилгээний аргыг тусгайлан судлан дараах байдлаар тайлбар хийлээ. Бид судалгаандаа нэр үл мэдэгдэх орчуулагчийн эртний бөгөөд шүлэглэсэн орчуулгыг олж судалгаанд оруулсан. Энэ орчуулга нэг талаас чадварлаг орчуулга байхаас гадна цээжлэхэд хялбар болох нь тогтоогдож байна. Тухайлбал:

Хямарсан халууны эмчилгээг
Халуун бүхнийг арилгагч
Хонлэн, банздоо, балига, гурван үр
Хойтой, бас жуган, мана, сороол, мэхээр найруулж
Ханиад, уушгины хямраан талхыг өгвөл
Хямарсан хуучин ханиадны урхаг
Хөх цайвар цэр гарах ба
Амьсгал амаргүй болох тэргүүтнийг
Амарлиулахад тустай хэмээмүй гэсэн байдаг.

Энэхүү шүлэглэсэн орчуулгад дандаа “х” үсгээр толгой холбосноос гадна шинж тэмдэг, өвчний оношийг хамтатган гаргасан байна. Энэ жоронд нийт 11 хөл эм орсон ба бүгдийг нь дараалуулан багтаасан нь сонирхолтой. Дараагийн жорыг 5 мөрөнд багтаан уудаг бус хамраар татдаг эмийг:

Хоёр зүйлийн арвай, бугын өөхтэй найруулж
Хамрын нүхээр нь сайтар утваас
Хамрын ханиад хурдан арилна.
Манабадар, сэрдэг арүр найруулсан талх
Магад ханиад томууг арилган чадюу хэмээн шүлэглэжээ.

Хүүхэд, нялхсын ханиаданд үндсэн эм түшмэл гурав дээр хэрхэн нэмэр тавихыг тодорхой дурдсан. Хэрвээ энэ жороор эмчилж чадахгүй бол өөр ямар хувилбар байдгийг, хавсарсан эм болох гурван сэрүүн, мэхээр, сороолтой найруулбал дэм өгөхөөс гадна ямар сэтгэл засал хийхийг заасан байдаг. Үүнд:

Хүүхэд нялхсын халуунд түшмэл гурав тустай
Хүйтний хувь их бөгөөс даль нэмнэ
Хэрэв эс эдгэрвээс тунгалаг тав ч тустай
Уушгины халуун ханиаданд гурван сэрүүн
Үхэр мэхээр, сороолтой найруулж өгвөөс дэмтэй
Хүүхдийн адад таван сахиусны
Тахил тавиулж, уншлага уншуул гэжээ.

Хоолойн хижиг дагшуурын шалтгаан нь ерийн хижиг лугаа адил байдаг. Нөхцөл нь бузар буртаг, халдварт хөлс зэргийг үнэртэх, айж цочих, нойр тэнцвэргүй болох, хүйтэн ус их уусан зэргээс болдог[9]. Ялгавал: хий, шар, бадган, хурмал, хоолойн, уушгины, хижгийн, хамрын дагшуур зэрэг найм буй. Шинж нь найтаалгах, хамраас шингэн нус гоожих, хоолой багалзуур халуу оргиж хаагдах зэрэг болно гэж “Анагаах заслын рашааны ундралын гишүүнээс гарын авлагыг цөөлөн хураасан рашааны цагаан шүүдэр хэмээх оршвой” сударт бичжээ[10]. Энэ өвчний эмчилгээг Ламын гэгээн дараах байдлаар илэрхийлжээ.

Бөөрөнхий ар үр, мана, гүгэл, банзи, манчэн
Бүдүүн мэхээр, хонлэн, сороол, дагшийг найруулж
Хүчин төгс хөх гарьд ес хэмээгчээр
Хижиг, хямарсан нян халуун хийгээд
Хоолойн хижиг томуу бүхний рашаан мөн хэмээжээ.

Энэ мэт эх болсон 3 зүйл амьтан бүхнийг шалтгаан, үрийн өвчнөөс гэтэлгэн, тийн удирдах эмч, отчийн хутгийг түргэнээ олох болтугай гэж ерөөсөн байдаг.

Дүгнэлт:

1. Хамба Номун хан Лувсанданзанжанцангийн зохиосон 18-н хуудастай “Увдист рашааны дусал” номд хий, шар, бадган, бор, эс шингэсэн, бэтэг, хаван, халуун унгирал, эрхтэн, цул, сав, хэсэг бусаг зэрэг 22 өвчний эмчилгээний аргыг өөрийн туршлагаас гадна Энэтхэг, Төвөдийн анагаах ухааны мэргэдийн олон арван ном судар, гарын авлагыг нарийвчлан судалж бичсэн хамгийн итгэмжтэй эмчилгээний аргуудыг багтаасан бүтээл болох нь тодорхой байна.
2. Анагаах ухааны ёгт болон бэрх үг нь ихэнхдээ ургамлыг адил төстэй шинж байдлаар нь өөр утга бүхий нэрээр нэрлэж олоход амаргүй болгох эсвэл их бодож, эрэл хайгуул хийж байж олох зорилго агуулсны зэрэгцээ буруу тайлбарлавал жорд буруу ургамал оруулж найруулснаар эмийн үйлдэл гарахгүй болох гэмтэй. Тиймээс эмийн ёгт нэр, бэрх үгийг оновчтой тайлбарласнаар түүний үндсэн ойлголт, зүй тогтлыг гүнзгий ойлгон бүтээлчээр ашиглах, дан эмийг таних, хэрэглээг оновчтой болгох, шинэ жор найрлага зохион бүтээх өргөн боломж нээгдэнэ хэмээн үзэж байна.
3. Шинэ төрлийн коронавирусын халдварт хижиг өвчний эхний эс боловсорсон халууны үеийн өвчин болох ёс нь шинэ төрлийн коронавирус биед халдварласаны дараа дангаараа үл орших, харин шарын хурц бэлгэ чанарын эрхээр түүнтэй хавсарч улмаар шарыг хөдөлгөн халууныг үүсгэнэ. Эс боловсорсон халууны үеийн эмийн эмчилгээний үйлдлийн механизмыг задалж үзэхэд Мана-4-ийн тан нь халууныг арвидуулахгүйгээр бадган хийг дарна. Норов-7-гийн тан нь халууныг боловсруулах, хураах, нядлах үйлийг нэгэн зэрэг үйлдэнэ. Лидэр-7-ийн тан нь халууныг боловсруулах, нядлах, хөлрүүлж халууныг гадагшлуулах үйлдлийг үзүүлнэ.

Ном зүй:

1. *Ламын гэгээн Лувсанданзанжанцан* ཨཞབ་ཚེན་ཚོས་ཀྱི་རྒྱལ་པོའི་གསུང་འབུམ་ལས་མན་ངག་བདུད་རྩི་ཟེགས་མ་བཞུགས་སོ། *Модон барын төвөд судар.*
2. *Ишбалжир. Анагаах заслын рашааны ундралын гишүүнээс гарын авлагыг цөөлөн хураасан рашааны цагаан шүүдэр хэмээх оршвой”. Модон барын төвөд судар.*
3. *Жамбалчойжиданзанпэрэнлэй* གཙོ་རིག་བཟུན་བཅོས་མཚན་ངག་གི་སྒྲིང་པོ་རྩོམས་པོགས་གཙིག་ཏུ་བසྡུས་པ་མན་ངག་རིན་ཆེན་འབྱུང་གནས་བཞུགས་སོ། *Анагаах ухааны шашидир бүгдийн шимийг нэгэн зүгт хураасан увдисын эрдэнэ гарах орон оршвой. Модон барын төвөд судар.*
4. *Ламын гэгээн Лувсанданзанжанцан* ཨཞབ་ཚེན་ཚོས་ཀྱི་རྒྱལ་པོའི་གསུང་འབུམ་ལས་མན་ངག་བདུད་རྩི་ཟེགས་མ་བཞུགས་སོ། *Модон барын төвөд судар.*
5. *“Анагаах ухааны дөрвөн үндэс”. Найруулан орчуулсан Шин Хэлин. Үндэсний хэвлэлийн хороо. Бээжин. 2007*
6. *Анагаах ухааны язгуур үндсийн тайлбар тодруулагч зул. Төвөд хэлнээс орчуулсан Б.Болдсайхан. УБ, 2019*
7. *Ламын гэгээн Лувсанданзанжанцан* ཨཞབ་ཚེན་ཚོས་ཀྱི་རྒྱལ་པོའི་གསུང་འབུམ་ལས་མན་ངག་བདུད་རྩི་ཟེགས་མ་བཞུགས་སོ། *Модон барын төвөд судар.*
8. *“Анагаах ухааны дөрвөн үндэс”. Найруулан орчуулсан Шин Хэлин. Үндэсний хэвлэлийн хороо. Бээжин. 2007*
9. *Монголын уламжлалт анагаах ухааны эм найрлагын судлал. (Төслийн удирдагч академич Ш.Болд, академич Д.Цэрэнсодном) УБ, 2014, х.24*
10. *Болд Ш, Цэрэнсодном Д. Монголын уламжлалт анагаах ухааны дээж бичиг. Улаанбаатар, Адмон ХК, 2013, х-7*

The theory and practical significance of the versified translation for "Man ngag bdud rtsi zegs ma" written by Khamba Nomyn Khan

Ochirbat D[1], Shagdarsuren D[3], Tserendavga D[2], Bold Sh[3]

[1]Department of Mongolian Traditional Medicine, International School of Mongolian Medicine, MNUMS
[2]MNUMS
[3]Mongolian University of Pharmaceutical Sciences
E-mail: dochirbat@gmail.com, Tel:+976-99110990

Background: Khamba Nomyn Khan Luvsandanzanjantsan's "Man ngag bdud rtsi zegs ma" sutra was the main research material for doctors, researchers, and students of traditional medicine. The book "Man ngag bdud rtsi zegs ma" has 18 pages of the sutra and is one of the five main books in the traditional medicine of Khamba Nomyn Khan. He summarized his experience and lessons learned in differential treatment of fever, some of the most common diseases in women, and medical care for 22 diseases such as wind, bile, and phlegm, measles, mumps, gonorrhea, edema, cold, and so on. We have studied the medical treatment of colds from these treatments. Luvsandanzanjantsan was not only a famous scientist who penetrated many fields of knowledge but also expanded the research work of Mongolian medicine and became the first Mongolian doctor to study medicine, which is based on Tibetan medicine, based on the Indian Ayurvedic medicine in Outer or Khalkh Mongol. Our research, on the one hand, analyzes the versified translation of Luvsandanzanjantsang's "Man ngag bdud rtsi zegs ma," and on the other hand, explains the importance of theory and practice in the book with the example of medicine for treating gnyan rims, which means in modern medicine as coronavirus disease (COVID-19).
Aim: To explain the theoretical and practical significance of Lamyn Gegeen LuvsandanZanjantsan's *"Drops of Healing Nectar"* (poetic translation) by using the example of a medicine for treating the common cold.
Materials and Methods: Analysis refers to breaking down or separating components of an object or phenomenon selected for study. Through analytical reasoning, each essential characteristic of the object becomes more apparent within its constituent parts. Analysis is a necessary cognitive and logical process that accompanies the act of examining an object in detail. Using this approach, the study analyzed and interpreted the medicinal applications for treating the common cold described in Lamyn Gegeen LuvsandanZanjantsan's *"Drops of Healing Nectar."* The results of the analysis were synthesized using the analysis–synthesis method.
Results: The main material of this study, *"Drops of Healing Nectar"* by LuvsandanZanjantsan, served as a key reference for medical students of the time. The text made the study of *"The Root of Therapeutics"* from the classical Indian and Tibetan medical work *"The Four Tantras of Medicine"* more accessible and comprehensible. [5]
Conclusion: The "Drops of Healing Nectar," an 18-page treatise written by Khamba Nomun Khan LuvsandanZanjantsan, includes treatment methods for 22 diseases such as disorders of wind (*rlung*), bile (*mkhris-pa*), phlegm (*bad-kan*), blood, edema, fever, inflammation, and organ-specific ailments. Drawing not only from his own experience but also from numerous authoritative Indian and Tibetan medical texts, this work compiles the most reliable treatment methods known at the time.

Keywords: Luvsandanzanjantsan, Traditional medicine, Colds, Translation, Treatments